



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2020 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 14

Мандалговь

Нэрэмжит болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн 20.1.12 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Аймгийн Онцгой байдлын газарт Сайнцагаан сумын уугуул 2007 онд Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт ой хээрийн түймэр унтраахаар явсан МИ-8 нисдэг тэрэгний осолд орж амь насаа алдсан комиссар Доржийн Батбаатарын нэрэмжит гэрэлт хөшөө, талбайг байгуулахыг зөвшөөрсүгэй.

Хоёр: Д.Батбаатарын түүхэн гавьяаг залгамж хойч үедээ түгээн дэлгэрүүлж, олон нийтэд сурталчлан ардаршуулахад идэвх санаачлагатай ажиллахыг тус Онцгой байдлын газрын дарга (М.Адьяабаатар)-д үүрэг болгосугай.

Гурав: Гурав.Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА С.СҮХБААТАР





ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2020 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 18

Мандалговь

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн ээжүүдийг
“Алдарт эх” одонгоор шагнуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 3 дугаар бүлгийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн 20.1.8, Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн 4.1.1, 4.1.2 дахь заалтууд, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2011 оны 116 дугаар зарлигийг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. “Алдарт эх” 1, 2 дугаар одонгоор шагнуулах ээжүүдийн нэрсийг 1-р хавсралтаар, “Алдарт эх” нэгдүгээр одонгоор шагнуулах 8 ээжийн анкетыг 2-р хавсралтаар, “Алдарт эх” хоёрдугаар одонгоор шагнуулах 154 ээжийн анкетыг 3-р хавсралтаар тус тус баталж нийт 162 ээжийг шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжилсугай

Хоёр. “Алдарт эх” одонгоор шагнуулах ээжүүдийн материалыг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүрдүүлж Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга (Ц.Мөнгөнцоож) - д үүрэг болгосугай.

ДАРГА

С.СҮХБААТАР



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИЙН
ТОГТООЛ**

2020 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 19

Мандалговь

Монгол Улсын цол хүртээх, одон,
медалиар шагнуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн 20.1.8 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

Нэг: Банк санхүүгийн салбарт олон жил, үр бүтээл, идэвх зүтгэл гарган ажилласан Хулд сумын Уул багийн ахмад настан Сугирын Халзанхүүг Монгол Улсын Төрийн дээд шагнал “ Гавьяат эдийн засагч ” цолоор шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжилсугай.

Хоёр: Шагналын материалыг холбогдох хууль, журам зааврын дагуу бүрдүүлж Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэхийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Ц.Мөнгөнцоож/-д үүрэг болгосугай

ДАРГА С. СҮХБААТАР





**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2020 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 20

Мандалговь

Монгол Улсын цол хүртээх, одон,
медалиар шагнуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн 20.1.8 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

Нэг: Хүнс хөдөө аж ахуйн салбарт олон жил, үр бүтээл, идэвх зүтгэл гарган ажилласан Өндөршил сумын Бөхт багийн ахмад настан Сэмбээгийн Ухнааг Монгол Улсын Төрийн дээд шагнал “ Хүнс, хөдөө аж ахуйн гавьяат ажилтан ” цолоор шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжилсугай.

Хоёр: Шагналын материалыг холбогдох хууль, журам зааврын дагуу бүрдүүлж Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэхийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Ц.Мөнгөнцоож/-д үүрэг болгосугай

ДАРГА



С.СҮХБААТАР



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2020 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 91

Мандалговь

Монгол Улсын цол хүртээх, одон,
медалиар шагнуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн 20.1.8 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

Нэг: Хүнс хөдөө аж ахуйн салбарт олон жил, үр бүтээл, идэвх зүтгэл гарган ажилласан Өндөршил сумын Бөхт багийн ахмад настан Түнтүүгийн Шархүүг Монгол Улсын Төрийн дээд шагнал “Хүнс, хөдөө аж ахуйн гавьяат ажилтан” цолоор шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжилсугай.

Хоёр: Шагналын материалыг холбогдох хууль, журам зааврын дагуу бүрдүүлж Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэхийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Ц.Мөнгөнцоож/-д үүрэг болгосугай

ДАРГА



С.СҮХБААТАР



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИЙН
ТОГТООЛ**

2022 оны 03 сарын 03 өдөр

Дугаар 22

Мандалговь

Монгол Улсын цол хүртээх, одон,
медалиар шагнуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн 20.1.8 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

Нэг: Соёл урлагийн салбарт олон жил, үр бүтээл, идэвх зүтгэл гарган ажилласан Сайнцагаан сумын харьяат соёл урлагын байгууллагын ахмад ажилтан Дэмбэрэлийн Ганболдыг Монгол Улсын Төрийн дээд шагнал “Соёлын гавьяат зүтгэлтэн” цолоор шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжилсугай.

Хоёр: Шагналын материалыг холбогдох хууль, журам зааврын дагуу бүрдүүлж Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэхийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Ц.Мөнгөнцоож/-д үүрэг болгосугай

ДАРГА



С.СҮХБААТАР



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2020 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 23

Мандалговь

Монгол Улсын цол хүртээх, одон,
медалиар шагнуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн 20.1.8 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

Нэг: Сэтгүүл зүйн салбарт олон жил, үр бүтээл, идэвх зүтгэл гарган ажилласан Өндөршил сумын харьяат Нацагдоржийн нэрэмжит шагналт зохиолч, сэтгүүлч Цэрэнтулгын Түмэнбаярыг Монгол Улсын Төрийн дээд шагнал “Соёлын гавьяат зүтгэлтэн” цолоор шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжилсугай.

Хоёр: Шагналын материалыг холбогдох хууль, журам зааврын дагуу бүрдүүлж Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэхийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Ц.Мөнгөнцоож/-д үүрэг болгосугай

ДАРГА



С.СҮХБААТАР



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2020 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 24

Мандалговь

Монгол Улсын цол хүртээх, одон,
медалиар шагнуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн 20.1.8 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

Нэг: Соёл урлагийн салбарт олон жил, үр бүтээл, идэвх зүтгэл гарган ажилласан Өндөршил сумын Соёлын төвийн эрхлэгч Төмөрхүүгийн Мөнхцэцэгийг Монгол Улсын Төрийн дээд шагнал “Соёлын гавьяат зүтгэлтэн” цолоор шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжилсугай.

Хоёр: Шагналын материалыг холбогдох хууль, журам зааврын дагуу бүрдүүлж Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэхийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Ц.Мөнгөнцоож/-д үүрэг болгосугай

ДАРГА



С.СҮХБААТАР



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2020 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 25

Мандалговь

Монгол Улсын цол хүртээх, одон,
медалиар шагнуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн 20.1.8 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

Нэг: Автотээврийн салбарт олон жил, үр бүтээл, идэвх зүтгэл гарган ажилласан Сайнцагаан сумын 9 дүгээр багийн ахмад настан Цэгмидийн Дониддавгыг Монгол Улсын Төрийн дээд шагнал “ Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон ” оор шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжилсугай.

Хоёр: Шагналын материалыг холбогдох хууль, журам зааврын дагуу бүрдүүлж Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэхийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Ц.Мөнгөнцоож/-д үүрэг болгосугай

ДАРГА



С.СҮХБААТАР



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2020 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 26

Мандалговь

Монгол Улсын цол хүртээх, одон,
медалиар шагнуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн 20.1.8 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

Нэг: Хөдөө аж ахуйн салбарт олон жил, үр бүтээл, идэвх зүтгэл гарган ажилласан Сайнцагаан сумын 8 дугаар багийн ахмад настан Амаажавын Таяаг Монгол Улсын Төрийн дээд шагнал “ Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон ” -оор шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжилсугай.

Хоёр: Шагналын материалыг холбогдох хууль, журам зааврын дагуу бүрдүүлж Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэхийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Ц.Мөнгөнцоож/-д үүрэг болгосугай

ДАРГА



С.СҮХБААТАР



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2020 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 24

Мандалговь

Монгол Улсын цол хүртээх, одон,
медалиар шагнуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн 20.1.8 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

Нэг: Төрийн захиргаа, нутгийн өөрөө удирдах байгууллагад олон жил, үр бүтээл, идэвх зүтгэл гарган ажилласан Эрдэнэдалай сумын ахмад настан Дашзэвэгийн Баатарыг Монгол Улсын Төрийн дээд шагнал “ Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон ” оор шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжилсугай.

Хоёр: Шагналын материалыг холбогдох хууль, журам зааврын дагуу бүрдүүлж Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэхийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Ц.Мөнгөнцоож/-д үүрэг болгосугай

ДАРГА  ССҮХБААТАР





**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2020 оны 03 сарын 03 өдөр

Дугаар 08

Мандалговь

Монгол Улсын цол хүртээх, одон,
медалиар шагнуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн 20.1.8 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

Нэг: Мал аж ахуйн салбарт олон жил, үр бүтээл, идэвх зүтгэл гарган ажилласан Говь-Угтаал сумын ахмад настан Жамбын Намсрайг Монгол Улсын Төрийн дээд шагнал “ Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон ” оор шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжилсугай.

Хоёр: Шагналын материалыг холбогдох хууль, журам зааврын дагуу бүрдүүлж Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэхийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Ц.Мөнгөнцоож/-д үүрэг болгосугай

ДАРГА



С.СҮХБААТАР



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2020 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 29

Мандалговь

Монгол Улсын цол хүртээх, одон,
медалиар шагнуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн 20.1.8 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Дундговь аймгийн төр, төрийн бус байгууллага, боловсрол, хөдөө аж ахуй, эрүүл мэнд, санхүү, хэвлэл мэдээлэл, шуудан үйлчилгээ, авто тээврийн салбарт олон жил, үр бүтээл, идэвх зүтгэл гарган ажилласан иргэдийн нэрсийг хавсралтаар баталж, Монгол Улсын Төрийн дээд шагнал одон, медалиар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжилсугай.

Хоёр. Шагналын материалыг холбогдох хууль, журам зааврын дагуу бүрдүүлж Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэхийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Ц.Мөнгөнцоож/-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 23 дүгээр сарын
23 ны өдрийн 29 тогтоолын хавсралт



“Алтан гадас одон”-гоор:

1. Лувсан-Ишийн Даарийжав – Сайнцагаан сумын Нэгдсэн эмнэлгийн ахмад настан
2. Пүрэвийн Цэндхүү – Сайнцагаан сум, Мэдээлэл холбоо сүлжээ ХХК-ний Дундговь аймаг дахь газрын ахмад настан
3. Доржийн Эрдэнэсугир – Сайнцагаан сумын 3 дугаар багийн ахмад настан
4. Дашдаваагийн Бүдээ – Сайнцагаан сумын 5-р багийн ахмадын зөвлөлийн дарга
5. Лхамжавын Оргодол – Онцгой байдлын газрын ахмад настан
6. Банзрагчийн Цэрэн- Өндөршил сумын Талын нар багийн ахмад настан
7. Бадамгаравын Цэрэнлхам – Гурвансайхан сумын 4-р багийн ахмад настан
8. Бадарчийн Дэмбэрэлням- Сайнцагаан сумын ахмад настан
9. Сүрэнхорын Долгор – Сайнцагаан сумын 3-р ахмад настан
10. Пунцагын Нарантуяа – Эрдэнэдалай сумын 4-р багийн өндөр настан
11. Шатарсүрэнгийн Чимэдрэгзэн- Эрдэнэдалай сумын 4-р багийн өндөр настан
12. Цэндоогийн Намсрайдорж - Эрдэнэдалай сумын 5-р багийн өндөр настан
13. Суурийн Баатардорж - Эрдэнэдалай сумын 5-р багийн өндөр настан
14. Маньбадарын Агаан- Эрдэнэдалай сумын 4-р багийн өндөр настан
15. Хандсүрэнгийн Сумъяа- Өндөршил сумын 2-р багийн ахмад настан
16. Дашдэндэвийн Тэрбиш – Сайнцагаан сумын харъяат ахмад настан
17. Бандиагийн Баярсайхан – Хулд сумын Мандахговь ХХК-ны захирал
18. Хондгойн Банзрагч – Луус сумын ахмад настан
19. Дагдангийн Ганхуяг – Луус сумын ахмад настан, малчин
20. Сандагийн Оргодол – Луус сумын ахмад настан
21. Сандагийн Эрдэнэбаатар – Сайнцагаан сумын 7-р багийн ахмад настан
22. Дашдаваагийн Аюурзана – Сайнцагаан сумын өндөр настан
23. Ширнэндоржийн Гантулга – Сайнцагаан сумын ахмад настан
24. Дүгэржавын Доржсүрэнхор – Сайнцагаан сумын ахмад настан
25. Хайдавжамцын Мөнхбат – Говь-Угтаал сумын өндөр настан
26. Готовын Жамбал - Говь-Угтаал сумын өндөр настан
27. Дэмбэрэлийн Норжинсүрэн – Дэрэн сумын өндөр настан
28. Баавгайн Сүхээ – Сайнцагаан сумын өндөр настан
29. Гомбожавын Адъяасүрэн – Цагаандэлгэр сумын өндөр настан
30. Сэрээтэрийн Бямбаа – Сайнцагаан сумын өндөр настан

“Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар:

1. Чимэдцэрэнгийн Галбадрах –Байгаль орчин аялал жуулчлалын газрын жолооч
2. Тулгын Гунгаа –Өндөршил сумын Талын нар багийн ахмад настан
3. Лувсандагвын Батсүмбэр –Өндөршил сумын Талын нар багийн ахмад настан
4. Цэдэнжавын Баатар – Луус сумын харъяат, ахмад настан
5. Даваасамбуугийн Уранчимэг –Сайнцагаан сумын 7-р цэцэрлэгийн нярав
6. Гомбын Оюунчимэг - Сайнцагаан сумын 7-р цэцэрлэгийн арга зүйч
7. Цэрэндашийн Сувдантуяа- Аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын дэд дарга
8. Дэндэвийн Түдэв –Сайнцагаан сумын Далай багийн малчин, ахмад настан
9. Баярсайханы Лхагва-Очир- Хулд сумын малчин
10. Шүхэрийн Төмөрсүх –Цагаандэлгэр сумын өндөр настан
11. Надмидсүрэнгийн Мөнхцэцэг –Өндөршил сумын ЕБС-ийн захирал асан, сумын ИТХ-ын төлөөлөгч
12. Наймаагийн Дэлгэрсайхан - Өндөршил сумын ЕБС-ийн захирал
13. Доржийн Нарантуяа - Өндөршил сумын ЕБС-ийн тогооч
14. Ёндонгийн Оюунтунгалаг- Өндөршил сумын ЕБС-ийн бага ангийн багш



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2020 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 30

Мандалговь

Журам батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын а, н, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Журам батлагдсантай холбогдуулан энэхүү тогтоолыг орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хүргүүлэх, орон нутгийн өмчит хуулийн этгээд болон сумын өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (М.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

Гурав. “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ыг 2020 оны 04 дүгээр сарын 01-нээс мөрдөж ажиллахыг Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагуудад үүрэг болгосугай.

Дөрөв. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, 2018 оны 77 дугаар тогтоол тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



С.СҮХБААТАР

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 43 дугаар сарын
24-ны өдрийн 30 тогтоолын хавсралт

ОРОН НУТГИЙН ӨМЧИД ЭД ХӨРӨНГӨ ОЛЖ АВАХ, БҮРТГЭХ, ДАНСНААС ХАСАХ, ШИЛЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөнд хамаарах үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг олж авах, бэлтгэх, шилжүүлэх, худалдах, акталж устгах, данснаас хасах тэдгээртэй холбогдон гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх, биелэлт гүйцэтгэлийг тооцож, тайлагнахад энэхүү журмыг баримтлана.
- 1.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, акталж данснаас хасах, худалдах, шилжүүлэх тухай саналаа энэ журамд заасны дагуу Орон нутгийн өмчийн газарт тавьж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар шийдвэрлүүлнэ.
- 1.3. Сумын харьяа орон нутгийн өмчит хуулийн этгээд нь үл хөдлөх хөрөнгө, тээврийн хэрэгслийг /мотоциклоос бусад/ энэ журмын дагуу баримт бүрдүүлэн сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрийн хамт Орон нутгийн өмчийн газарт уламжилж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар шийдвэрлүүлнэ.
- 1.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн үл хөдлөх хөрөнгийн хувьд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтыг баримтлана.
- 1.5. Сумын харьяа орон нутгийн өмчит хуулийн этгээд мотоцикл болон бусад хөдлөх хөрөнгийг олж авах, акталж данснаас хасах, худалдах, шилжүүлэх тухай саналаа энэ журмын дагуу баримт бүрдүүлэн сумын ИТХ-д уламжилж шийдвэрлүүлнэ.
- 1.6. Орон нутгийн өмчийн газар нь орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгө олж авах, бэлтгэх, шилжүүлэх, худалдах, актлах талаар ирүүлсэн саналыг хянан үзээд энэ журамд заасны дагуу аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд оруулан шийдвэрлүүлж, шийдвэрийг тухайн байгууллагад хүргүүлнэ.
- 1.7. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах зөвлөл үйл ажиллагаандаа энэхүү журмыг баримтлана.
- 1.8. Хөрөнгө худалдах, хувьчлах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлнэ.

Хоёр. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн бүрдүүлэх материал

2.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь энэ журмын 1.2-т заасан асуудлыг шийдвэрлүүлэхдээ дор дурдсан бичиг баримтаас тухай харилцаанд хамааралтай баримт материалыг бүрдүүлж цаасаар болон файлаар ирүүлнэ. Үүнд:

2.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авахдаа:

2.2.1. худалдан авах санхүүжилтийн эх үүсвэрийг баталсан эрх бүхий байгууллагын шийдвэр

2.2.2. эдийн засгийн тооцоо, үндэслэл, зах зээлийн үнийн харьцуулсан судалгаа, худалдан авах дээд үнийн санал

2.2.3. худалдан авах хөрөнгийн техникийн тодорхойлолт

2.2.4. хуулийн этгээдийн өмч хамгаалах зөвлөлийн хурлын тэмдэглэл, дүгнэлт

2.3. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө акталж данснаас хасах болон худалдахдаа:

2.3.1. хуулийн этгээдийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хурлын тэмдэглэл, дүгнэлт

2.3.2. холбогдох мэргэжлийн байгууллагын акт, дүгнэлт

2.3.3. ашиглалтын хугацаа дуусаагүй, үлдэгдэл өртөгтэй боловч ашиглах боломжгүй болсон үндсэн хөрөнгийн эвдрэл, гэмтлийн шалтгааныг тогтоосон дүгнэлт, хохирол барагдуулсныг нотлох баримт, сэргээн засварлаж ашиглахад шаардагдах эдийн засгийн тооцоо үндэслэл

2.3.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн биет болон биет бус үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг тогтоосон хэсгийг хуулбарлан, “Хуулбар үнэн” тэмдэгээр баталгаажуулан ирүүлэх

2.3.5. байгалийн гэнэтийн аюул, техникийн осол, гэмтэлд өртсөн эд хөрөнгийн шалтгааны тухай холбогдох байгууллагын акт дүгнэлт

2.3.6. үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй номыг устгах талаар гаргасан холбогдох байгууллагын дүгнэлт

2.3.7. үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй буу, галт зэвсгийн талаар Цагдаагийн байгууллагын албан бичиг, дүгнэлт

2.3.8. түүх, соёлын дурсгалт зүйлсийн талаарх аливаа шийдвэрийг гаргахад соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын санал

2.3.9. Актлах хөрөнгийн мэдээлэл /хавсралт маягтын дагуу/

2.3.10. Актлах хөрөнгийн өнгөт фото зураг

2.3.11. бусад шаардлагатай баримт материал

2.4. Үл хөдлөх хөрөнгийн хувьд энэхүү журмын 2.3-д зааснаас гадна дараах баримт, мэдээллийг ирүүлнэ

2.4.1. үл хөдлөх хөрөнгө байрлаж буй газрын эзэмших /ашиглах/ эрхийн санхүүгийн тайланд бүртгэсэн үнэлгээ, гэрчилгээ, газар эзэмшүүлэх /ашиглуулах/ гэрээ, кадастрын зургийн хуулбар,

2.4.2. үл хөдлөх хөрөнгөнд хийсэн их болон урсгал засварын зардал, тухайн эд хөрөнгөтэй холбоотой бусдын өмнө хүлээсэн хариуцлагын /зээл, өрийн барьцаа, баталгаа гэх мэт/ болон ашиглалтын талаарх мэдээлэл

2.4.3. барилгын паспортын хуулбар, орчны тойм зураг, байгуулалтын зураг /план/, гадна, дотор талын өнгөт фото зураг, инженерийн шугам сүлжээний техникийн зургийн хуулбар, бусад баримт бичиг,

2.4.4. үл хөдлөх хөрөнгийг бусад этгээдтэй хамтран эзэмшиж, өмчилдөг тохиолдолд тухайн барилгыг бүхэлд нь зураглан, хөршүүдтэй хамтран баталсан заагийн актын хуулбар

2.4.5. худалдах үл хөдлөх хөрөнгөнд эрх бүхий байгууллагаар хийлгэсэн үнэлгээний тайлан

2.4.6. үл хөдлөх хөрөнгийг худалдах бол түүнд ногдох газрын хэмжээ, үнэлгээ, гэрчилгээ, кадастрын зураг /салгаж хийлгэсэн/

2.4.7. орон нутгийн болон орон нутгийн оролцоотой хуулийн этгээдийн эзэмшиж, ашиглаж буй газрын нэгж талбарыг хуваах, нэгтгэх зэргээр өөрчлөлт орж байгаа нөхцөлд газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас авсан зөвшөөрөл, холбогдох дүгнэлт

2.4.8. газрын тухай хуулийн 39.1.3-д заасны дагуу тухайн байгууллагын газар эзэмших эрхийг дуусгавар болгосон тухай Засаг даргын шийдвэр, холбогдох материал

2.4.9. Актлах барилгын мэдээлэл /хавсралт маягтын дагуу/

2.5. тээврийн хэрэгслийн хувьд энэхүү журмын 2.3-д зааснаас гадна дараах баримт, мэдээллийг ирүүлнэ

2.5.1. тээврийн хэрэгслийн гэрчилгээ, техник ашиглалтын дэвтэр, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр төлөгчийн гэрчилгээний хуулбар

2.5.2. техникийн үзүүлэлт, 3 талаас авсан өнгөт фото зураг

2.5.3 төслийн шугамаар ашиглагдаж байсан бол гаалийн татвар төлөлтийн мэдээлэл, холбогдох баримт

2.5.4. ашиглалтын сүүлийн 3 жилийн сэргээн босголтын зардлын дүн

2.5.5. тээврийн хэрэгслийн хувийн хэргийн Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөрийг төлсөн болон техникийн үзлэгт орсон талаарх эрх бүхий этгээдийн хийсэн тэмдэглэл, гарын үсэг, тамга бүхий хэсгийн хуулбар

2.5.6. Актлах тээврийн хэрэгслийн мэдээлэл /хавсралт маягтын дагуу/

2.6. Механизм, тоног төхөөрөмжийн хувьд энэхүү журмын 2.3, 2.5-д зааснаас гадна дараах баримт мэдээллийг ирүүлнэ

2.6.1. механизм, тоног төхөөрөмжийн ашиглалтын паспортын хуулбар

2.6.2. барилга байгууламжид суурилагдсан бол энэ тухай мэдээлэл

2.7. Биет бус хөрөнгийн хувьд энэ журмын 2.3-д зааснаас гадна дараах баримт, мэдээллийг ирүүлнэ

2.7.1. биет бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй “газар эзэмших эрх”-ийн асуудлыг шийдвэрлүүлэхэд газар эзэмших/ашиглах эрхийн гэрчилгээ, кадастрын зураг, тухайн газар дээр барилга байгууламжийн жагсаалт, газар шилжүүлэх болсон үндэслэл, шалтгааны тайлбар

2.7.2. програм хангамжийн нэр, үнэ, элэгдэл, хорогдол, лиценз эзэмшигч болон ашиглалтын талаарх мэдээллийг жагсаалтаар

2.8. Хувьчлах орон сууцны хувьд 2.3, 2.4-д зааснаас гадна дараах баримт, мэдээллийг ирүүлнэ

2.8.1. Орон сууц өмчлөх хүсэлтэй иргэний үнэмлэхийн хуулбар

2.8.2. Орон сууц өмчлэх хүсэлтэй иргэний тухайн орон сууцанд амьдардаг тухай харъяалах баг хорооны Засаг даргын тодорхойлолт

2.8.3. цахилгаан эрчим хүч болон дулаан, ус зэрэг эзэмшилт, ашиглалтын өр төлбөрийн тооцоогүй тухай холбогдох байгууллагын тодорхойлолт

2.8.4. орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газрын холбогдох байгууллагын сууц эзэмшилт, ашиглалтын болон сууцны хөлс төлөлтийн тооцоогүй тухай тодорхойлолт

2.8.5. харъяалагдах сууц өмчлөгчдийн холбооны сууц эзэмшлийн болон сууцны хөлс, суурин утас, интернет, кабелийн телевиз зэрэг ашиглалтын хөлс төлөлтийн тооцоогүй тухай тодорхойлолт

2.9. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө балансаас балансад шилжүүлэхдээ:

2.9.1. балансаас балансад шилжүүлэх бол өмч эзэмшигч байгууллагын зөвшөөрөл болон шилжүүлэн авах хуулийн этгээдийн хүсэлт

2.9.2. Шилжүүлэх хөрөнгийн мэдээлэл /хавсралт маягтын дагуу/

2.9.3. Шилжүүлэх хөрөнгийн фото зураг

2.9.4. үл хөдлөх хөрөнгийг шилжүүлэх бол түүнд ногдох газрын хэмжээ, үнэлгээ, гэрчилгээ, кадастрын зураг /салгаж хийлгэсэн/

2.9.5. орон нутгийн болон орон нутгийн оролцоотой хуулийн этгээдийн эзэмшиж, ашиглаж буй газрын нэгж талбарыг шилжүүлж байгаа нөхцөлд газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас авсан зөвшөөрөл, холбогдох дүгнэлт

2.9.6. элэгдэл хорогдлын шимтгэлээр өртөгөө нөхсөн хөрөнгийг шилжүүлэх бол тухайн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналын хамт

Гурав. Орон нутгийн өмчит хуулийн этгээд эд хөрөнгө олж авах

3.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгийг эрх бүхий байгууллагаас баталсан төсөв болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу худалдаж авах, үйлдвэрлэл, ажил үйлчилгээний үр дүнд бий болгох, эсхүл иргэн, хуулийн этгээдээс үнэ төлбөргүй шилжүүлж авах, түүнчлэн хандив, тусламж, бэлэглэл, эрх залгамжлах болон хуульд заасан бусад үндэслэлээр олж авна.

3.2. Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар автомашин шинээр худалдан авах санал ирүүлэхдээ илүүдэлтэй эсхүл ашиглалтын шаардлага хангахгүй автомашиныг худалдах, шилжүүлэх, актлах асуудлыг хамтад нь тавьж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар шийдвэрлүүлнэ.

3.3. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь газар эзэмших эрх шинээр авах саналаа тухай жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулан, холбогдох газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, сумын газрын даамалд хүсэлт гарган шийдвэрлүүлнэ. Газар эзэмших/ашиглах эрх үүсмэгц түүнийг үнэлж, санхүүгийн тайланд бүртгэнэ.

Дөрөв. Орон нутгийн өмчит хуулийн этгээд эд хөрөнгийг бүртгэх

4.1. Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний болон хандив, бэлэглэл, тусламжийн хүрээнд бий болсон хөрөнгийг санхүүжилтийн гүйцэтгэлээр эрх бүхий байгууллагын албан бичиг, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт, хөрөнгө тус бүрийн үнийн задаргааг харгалзан нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журамд заасны дагуу Монгол хэлээр, оновчтой нэршлээр данс бүртгэлд тусгана.

4.2. Батлагдсан эх үүсвэрээр бэлтгэсэн болон хандив, тусламж, бэлэглэл, төслийн шугамаар бий болсон хөдлөх хөрөнгийг бүртгэлд тусгахад Орон нутгийн өмчийн газраас зөвшөөрөл авах шаардлагагүй.

4.3. Батлагдсан эх үүсвэрээр бэлтгэж буй үл хөдлөх хөрөнгийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалт хариуцсан хэлтэс, нэгжээс хөрөнгө оруулалт, санхүүжилтийн гүйцэтгэл, хөрөнгийн жагсаалт, холбогдох бусад баримтыг аль нэг, эсвэл хэд хэдэн орон нутгийн өмчит хуулийн этгээдэд эзэмшүүлэх саналын хамт Орон нутгийн өмчийн газарт ирүүлж бүртгэлд тусгах, эзэмшигчийг тогтоох асуудлыг шийдвэрлүүлнэ.

4.4. Энэ журмын 4.2-д заасан хөрөнгийг хүлээн авч буй хуулийн этгээд тухайн иргэн, хуулийн этгээдийн зөвшөөрлийг албан ёсоор авч үндсэн болон эргэлтийн хөрөнгөөр нь ангилан, ашиглах хугацаа, чанар байдлыг нь харгалзан ашигласан хугацааны элэгдэл хорогдлын шимтгэлийг тооцож данс бүртгэлдээ тусгана.

4.5. Орон нутгийн өмчит хуулийн этгээд улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сан, зээл, тусламж, хандиваар бий болсон хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхэд үнэ өртөг, эзэмших хуулийн этгээд нь тодорхойгой болон маргаантай тохиолдолд Орон нутгийн өмчийн газарт асуудлаа тавьж шийдвэрлүүлнэ.

4.6. Улсын төсвийн тухай хуулийн дагуу хийсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ, орон нутгийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн өмчид хамаарах хандив, бэлэглэл, тусламжийн хүрээнд бий болсон эд хөрөнгийг ашиглалтад хүлээн авсан актыг үндэслэн эцсийн гүйцэтгэлийн дүнгээр Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журамд заасны дагуу үнэлж эргэлтийн болон үндсэн хөрөнгийн холбогдох данс бүртгэлд заавал тусгана.

4.7. Үндсэн хөрөнгийн дансанд Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартын “хүлээн зөвшөөрөлтийн зарчим” хангагдсан, үндсэн хөрөнгийн шинжийг хадгалсан хөрөнгийг бүртгэнэ.

4.8. Улс болон орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, хандив, бэлэглэл, тусламжийн хүрээнд бий болсон хөрөнгийг тухайн төрийн өмчит байгууллага ашиглаж байгаа боловч данс бүртгэлд тусгаагүй бол түүнийг зөрчил гэж үзэх бөгөөд тэдгээр хөрөнгийг данс бүртгэлд тусгах асуудлыг Орон нутгийн өмчийн газарт нэн даруй тавьж шийдвэрлүүлнэ.

Тав. Эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх

5.1. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр болон бусад шаардлагаар орон нутгийн өмчит хуулийн этгээд илүүдэлтэй буюу ашиглагдаагүй эд хөрөнгийг шилжүүлэх бусад байгууллагын өмчлөлд байгаа эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авахдаа өмч эзэмшигч байгууллагын зөвшөөрлийг авч, энэхүү журмын 2.7-д заасны дагуу бүрдүүлэн

Орон нутгийн өмчийн газарт ирүүлж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар шийдвэрлүүлнэ.

5.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрт зааснаар хөрөнгө хүлээлцэх ажлыг зохион байгуулж, баланс тайланд хөдлөл өөрчлөлтийг тусгана.

5.3. Үл хөдлөх хөрөнгө болон их хэмжээний хөдлөх үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тохиолдолд аймгийн Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулан хөрөнгө хүлээлцэх ажлыг зохион байгуулж болно.

5.4. Эд хөрөнгө шилжүүлэхтэй холбогдон гарах зардлыг хөрөнгө шилжүүлж авсан байгууллага хариуцна.

5.5. Үл хөдлөх хөрөнгө доорх газрын хамт шилжсэн тухай аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэр гарсан тохиолдолд газрын гэрчилгээ, кадастрын зураг, гэрээнд өөрчлөлт оруулж, шилжүүлэн авсан хуулийн этгээд өөрийн нэр дээр газар эзэмших эрхийг шилжүүлэх /гэрчилгээ гаргуулах/ арга хэмжээ авна.

Зургаа. Эд хөрөнгийг акталж, данснаас хасах

6.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь хагас болон бүтэн жилийн эд хөрөнгийн тооллогын дүн, өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлтээр цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон нь тогтоогдсон үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах саналаа энэхүү журмын 2.3 – 2.8-д заасан баримт материалын хамт Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар шийдвэрлүүлнэ.

6.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд аймаг, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрээр данснаас хасна:

6.2.1. элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон

6.2.2. ашиглалтын хугацаа нь дуусаагүй боловч ашиглах явцад хэн нэгний буруутай үйлдлээс болж эвдэрч гэмтэн цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын дүгнэлт гаргуулан буруутай этгээдээр хохирлыг барагдуулсан тохиолдолд

6.2.3. техник, технологийн болон хэрэглээний хоцрогдолд орж, зайлшгүй шинэчлэх шаардлагатай болсон

6.2.4. балансын үнээ бүрэн нөхөөгүй боловч байгалийн гэнэтийн аюул, техникийн осолд өртсөнөөс цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй болсон нь мэргэжлийн байгууллагаар тогтоогдсон

6.2.5. ашиглалтын явцад эвдэрч гэмтсэнээс засвар шинэтгэл хийж ашиглахад эдийн засгийн хувьд үр ашиггүй болох нь тооцоогоор нотлогдсон

6.3. Орон нутгийн өмчийн газар, сумын өмч хамгаалах зөвлөл данснаас хасах саналыг хүлээн авч, эд хөрөнгийг газар дээр нь нягтлан шалгаад аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэр гарах хүртэл эд хөрөнгийг байгууллагын удирдлагад хариуцуулж, энэ тухай протокол үйлдэн гарын үсэг зуралцана.

6.4. Аймаг, сумын ИТХ-ын Тэргүүлэгчид нь эд хөрөнгийг акталж данснаас хасахдаа дараах хэлбэрээр шийдвэрлэнэ:

6.4.1. эд хөрөнгийг худалдах

6.4.2. орон нутгийн өмчит бусад хуулийн этгээдэд шилжүүлэх

6.4.3. сэлбэг, материал, хоёрдогч түүхий эд болгон ашиглах

6.4.4. шууд устгах

6.4.5. барилга байгууламжийн хувьд тухайн газрыг цаашид ашиглах зориулалтын талаар чиглэл өгөх

6.4.6. газар дээрх болон доорх барилга байгууламжийг буулгах, ашиглаж болох материалыг үнэ тогтоон орлогод авах, хог хаягдлыг цэвэрлэх, газрыг нөхөн сэргээх

6.5. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрээр үл хөдлөх хөрөнгийг акталж, худалдахаар шийдвэрлэсэн тохиолдолд сумын өмч хамгаалах зөвлөлөөс худалдах ажлыг зохион байгуулна. Мөн сумын өмч хамгаалах зөвлөл шаардлагатай тохиолдолд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрээр тээврийн хэрэгслийн худалдах ажлыг зохион байгуулна.

6.6. Үл хөдлөх хөрөнгөнд их засвар хийгдэхэд засвар хийгдсэнээс гарсан хуучин материалыг Орон нутгийн өмчийн газрын хяналтан дор сум болон байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлөөр үнэлгээ хийлгэн эргэлтийн хөрөнгөнд бүртгэх эсхүл худалдан борлуулж, худалдсанаас орох орлогыг орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын дансанд 100 хувь төвлөрүүлнэ.

6.7. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрээр тээврийн хэрэгслийг акталж, сэлбэгээр худалдахаар шийдвэрлэсэн тохиолдолд тэдгээр хөрөнгийг автотээврийн хэрэгслийн улсын бүртгэл болон татвар төлөгчийн бүртгэлээс хасуулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

6.8. Акталсан тээврийн хэрэгслийг сэлбэгээр худалдан авсан этгээдэд тээврийн хэрэгслийн улсын дугаар шилжүүлэхийг хориглоно.

6.9. Орон нутгийн өмчит хуулийн этгээд татан буугдсан тохиолдолд түүний газар эзэмших/ашиглах эрхийг шилжүүлэн эрх залгамжлан эзэмших орон нутгийн өмчит

хуулийн этгээдийг тогтоож, саналаа газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

**Долоо. Орон нутгийн өмчит хуулийн этгээд эд хөрөнгө
олж авах, бэлтгэх, шилжүүлэх, худалдах, акталж данснаас
хасах шийдвэрийг хэрэгжүүлэх, тайлагнах**

7.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бэлтгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах тухай аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрийг Орон нутгийн өмчийн газар болон сум, байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хэрэгжүүлнэ.

7.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бэлтгэх, худалдах, шилжүүлэх, актлах тухай ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг тухайн хуулийн этгээдийн дарга /захирал/ хариуцан зохион байгуулж, биелэлтийг заасан хугацаанд холбогдох материалын хамт Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх үүрэг хүлээнэ.

7.3. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг акталж сэлбэг материал, хоёрдогч түүхий эд болгон ашиглах буюу худалдах, данснаас хасах шийдвэрийн хэрэгжилтийг устгалын акт, эргэлтийн хөрөнгөнд орлого болгосон тэмдэглэл, худалдсан тухай акт хэлбэрээр баталгаажуулан, гүйцэтгэлийн үр дүнг холбогдох данс бүртгэлд тусгана.

7.4. Тээврийн хэрэгслийг акталж данснаас хасах тухай шийдвэрийн биелэлтийг ирүүлэхдээ Автотээврийн үндэсний төвөөс автотээврийн хэрэгслийн улсын бүртгэл болон татвар төлөгчийн бүртгэлээс хассан тухай лавлагааг ирүүлнэ.

7.5. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь уг журмын 7.1-ээс 7.4 дүгээр зүйлийг хэрэгжүүлээгүй тохиолдолд Орон нутгийн өмчийн газрын саналыг үндэслэн Аймгийн иргэдийн хурлаас гарсан шийдвэрийг хүчингүйд тооцож шийдвэр гаргуулна.

Найм. Бусад

8.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй хөрөнгийн элэгдлийн хугацаа, хэмжээг тооцохдоо Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баримтлана.

8.2. Эрх бүхий байгууллагын шийдвэр, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу хийсэн хөрөнгийн дахин үнэлгээний үр дүн болон хөрөнгийн үнэлгээний залруулгыг холбогдох хууль тогтоомж, журам, зааврын дагуу данс бүртгэлд тусгана.

8.3. Орон нутгийн өмчит байгууллагын үндсэн хөрөнгө акталж худалдсанаас орох орлогыг орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын дансанд 100 хувь төвлөрүүлнэ.

8.4. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх хүртэлх хугацаанд тухайн эд хөрөнгөтэй холбоотой гарсан зардал, хөрөнгийн иж бүрдэл, чанар байдал, бүрэн бүтэн байдлыг тухайн байгууллагын удирдлага хариуцна.

8.5. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлага нь эд хөрөнгийг харуул хамгаалалттай байлгах үүрэг хүлээх бөгөөд дутагдал, зөрчил гарсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.

8.6. Хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалт, скаладын эмх цэгц зэрэгт үзлэг шалгалт хийж удаа дараа зөрчил гаргасан Орон нутгийн өмчит хуулийн этгээдэд Орон нутгийн өмчийн газрын саналыг үндэслэн үндсэн хөрөнгө бэлдэхийг зөрчил арилгах хүртэл Аймаг Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хязгаарлана.



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2020 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 31

Мандалговь

「 Хөрөнгөнд үнэлгээ тогтоож, худалдах, акталж
сэлбэг хэрэгсэлд бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 6.2.1 , 6.4 дэх хэсгийн 6.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Говь-Угтаал сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 19,400,000 /арван есөн сая дөрвөн зуун мянга/ төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй 53-39 ДУА улсын дугаартай УАЗ-31519 маркийн автомашины худалдах доод үнийг 1,500,000 /нэг сая таван зуун мянга/ төгрөгөөр, 1,900,000 /нэг сая есөн зуун мянга/ төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй бага оврын тракторыг акталж, данснаас хасах, 37,799,960 /гучин долоон сая долоон зуун ерэн есөн мянга есөн зуун жар/ төгрөгийн балансын үнэтэй, 28,349,969 /хорин найман сая гурван зуун дөчин есөн мянга есөн зуун жаран ес/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй, 52-08 ДУА улсын дугаартай Патриот маркийн автомашиныг акталж, данснаас хасах нэгдүгээр хавсралтаар , “Дундговь-Ус” Орон нутгийн өмчит үйлдвэрийн газарт 4,010,000 /Дөрвөн сая арван мянга/ төгрөгийг сэлбэг хэрэгслийг дансанд бүртгэж, балансаас балансад шилжүүлэхийг хоёрдугаар хавсралтаар тус тус зөвшөөрсүгэй.

Хоёр: Эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

Гурав: Эд хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад дор акталж данснаас хассаны дараа холбогдох хууль тогтоомж журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэж, тогтоолын биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэхийг Говь-Угтаал сумын тамгын дарга (Г.Эрдэнэцэцэг)-д даалгасугай.

Дөрөв: Говь-Угтаал сумын тамгын дарга (Г.Эрдэнэцэцэг), “Дундговь-Ус” Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын захирал (Д.Ганбаатар) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай. Үүнд:

- 2.1 Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллага болон сумын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах
- 2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх

Тав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР

**Говь-Утгаал сумын Засаг даргын Тамгын газрын актлах, худалдах,
сэлбэг хэрэгсэлд бүртгэх тээврийн хэрэгслийн мэдээлэл**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 12 дугаар сарын
23 ний өдрийн 31 тогтоолын нэгдүгээр хавсралт

Д/д	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Үйлдвэрлэсэн он	Ашиглалтад орсон огноо	Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
			Сери	дугаар						
1	УАЗ 31519	УАЗ	ДУА	53-39	2010	2010	55066	19,400,000	19,400,000	-
2	Бага оврын трактор				2009	2009		1,900,000	1,900,000	-
3	Патриот	УАЗ	ДУА	52-08	2016	2016	57094	37,799,960	9,449,990.10	28,349,969.90
Нийт дүн								59,099,960	30,749,990.10	28,349,969.90
								/тавин есөн сая ерөн есөн мянга есөн зуун жар/	/гучин сая долоон зуун дөчин есөн мянга есөн зуун ерэн төгрөг арван мөнгө/	/хорин найман сая гурван зуун дөчин есөн мянга есөн зуун жаран ес төгрөг ерөн мөнгө/

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 03 дугаар сарын
23-ний өдрийн 31 тогтоолын хоёрдугаар хавсралт

**Патриот автомашины тээврийн хэрэгслээс авах,
сэлбэг хэрэгслийн жагсаалт**

№	Сэлбэгийн нэр	х/н	тоо/ш	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Цахилгааны цээж утас	ком	1	50,000.00	50,000.00
2	Радиатор	ш	1	100,000.00	100,000.00
3	Жинам	ш	1	70,000.00	70,000.00
4	Күлекторын оруулах Хоолой	ш	1	50,000.00	50,000.00
5	Катушик	ш	2	30,000.00	60,000.00
6	Клапан	ш	1	60,000.00	60,000.00
7	Клапангийн таг	ш	1	30,000.00	30,000.00
8	Клапангийн тагны жийрэг	ш	1	10,000.00	10,000.00
9	Сэнс	ш	1	50,000.00	50,000.00
10	Сэнсний хүрээ	ш	1	25,000.00	25,000.00
11	Духны гинж	ш	1	150,000.00	150,000.00
12	Цахилгаан помп	ш	1	40,000.00	40,000.00
13	Кондишны жинам	ш	1	50,000.00	50,000.00
14	Агаар шүүгч	ш	1	5,000.00	5,000.00
15	Агаарын хоолой	ш	2	10,000.00	20,000.00
16	Статер	ш	1	120,000.00	120,000.00
17	Хойд нум	ком	1	80,000.00	80,000.00
18	Урд пүрш	ш	2	40,000.00	80,000.00
19	Мотрын ламп	ш	1	20,000.00	20,000.00
20	Урд хойд цафны шайриг	ш	8	15,000.00	120,000.00
21	Стуч	ш	8	40,000.00	320,000.00
22	Мотор	ш	1	2,500,000.00	2,500,000.00
Дүн					4,010,000.00 /дөрвөн сая арван мянган төгрөг/



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2020 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 32

Мандалговь

Автомашинд үнэлгээ тогтоож,
худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 6.2.1, 6.4 дэх хэсгийн 6.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Дундговь аймгийн Цагдаагийн газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 32,976,450 /гучин хоёр сая есөн зуун далан зургаан мянга дөрвөн зуун тавь/ төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй 13-90 ДУЭ улсын дугаартай SONATA6 маркийн автомашины худалдах доод үнийг 1,000,000 /нэг сая/ төгрөгөөр, 73-46 ДУА Sunny маркийн автомашиныг худалдах доод үнийг 800,000 /найман зуун мянга/ төгрөгөөр хавсралтын дагуу тогтоон дуудлага худалдаагаар худалдахыг зөвшөөрсүгэй.

Хоёр: Эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

Гурав: Эд хөрөнгийг худалдсаны дараа холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэхийг Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн дэд хурандаа (О.Амарсанаа)-д даалгасугай.

Дөрөв: Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА С.С. С.СҮХБААТАР



Аймгийн Цагдаагийн газрын нээлттэй дуудлага худалдаагаар худалдаалах эд хөрөнгийн жагсаалт



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 43 дугаар сарын
23-ний өдрийн 22 тогтоолын хавсралт

Д/Д	Тээврийн хэрэгслийн Төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Үйлдвэрлэсэн он	Ашиглалтад орсон огноо	Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан элгэдэл	Дуудлага худалдааны үнэ
			Сери	дугаар						
1	Суудлын	suplu	ДУА	73-46	2003	6/30/2012	192854	8,000,000.00	8,000,000.00	800,000
2	Суудлын	SONATA-6	ДУЭ	13-90	1998	1/12/2006	346816	24,976,450.00	24,976,450.00	1,000,000
Нийт дүн								32,976,450.00	32,976,450.00	1,800,000
								/Гучин хоёр сая есөн зүүн далан зургаан мянга дөрвөн зүүн тавь/	/Гучин хоёр сая есөн зүүн далан зургаан мянга дөрвөн зүүн тавь/	/Нэг сая найман зүүн мянга/



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2020 оны 03 сарын 03 өдөр

Дугаар 33

Мандалговь

Үндсэн хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт шаардлагатай нийт 13,725,000 /арван гурван сая долоон зуун хорин таван мянга/ төгрөгийн үнэтэй тоног төхөөрөмжийг хавсралтын дагуу бэлтгэж үндсэн хөрөнгөнд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга (Ц.Ганзориг)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай. Үүнд:

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2020 оны 4 дүгээр сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх;

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ) -д үүрэг болгосугай.

ДАРГА С.СҮХБААТАР



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 23 дугаар сарын
23-ний өдрийн 33 тогтоолын хавсралт

**Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын
Үндсэн хөрөнгөнд бүртгэх хөрөнгийн жагсаалт**

№	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Дэлгэц	ш	2	350,000	700,000
2	Дисанца	ш	1	350,000	350,000
3	Өнгөт хэвлэгч/Epson-L-1300	ш	1	1,750,000	1,750,000
4	Тог баригч	ш	4	230,000	920,000
5	Цаг бүртгэлийн төхөөрөмж/uf100/	ш	1	230,000	230,000
6	Хэвлэгч /хар/	ш	2	350,000	700,000
7	Камер/Вэб/	ш	4	90,000	360,000
8	Зөөврийн хард	ш	1	170,000	170,000
9	Төмөр хөлтэй эргэдэг сандал	ш	15	120,000	1,800,000
10	Дарга сандал	ш	1	680,000	680,000
11	Төмөр шкаф	ш	5	380,000	1,900,000
12	Сейф	ш	1	580,000	580,000
13	Суурин компьютер	ш	2	1,792,500	3,585,000
	Нийт дүн				13,725,000 /арван гурван сая долоон зуун хорин таван мянга/



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2020 оны 03 сарын 03 өдөр

Дугаар 34

Мандалговь

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх, акталж данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Дэрэн сумын Цэцэрлэгийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 978,500 /есөн зуун далан найман мянга таван зуу/ төгрөгийн балансын үнэтэй, 873,930 /найман зуун далан гурван мянга есөн зуун гуч/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй нэгдүгээр хавсралтад дурьдсан төмөр хашааг Засаг даргын тамгын газарт балансаас балансад шилжүүлэх, 265,413 /хоёр зуун жаран таван мянга дөрвөн зуун арван гурав/ төгрөгийн балансын үнэтэй, 209,175 /хоёр зуун есөн мянга нэг зуун далан тав/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй хоёрдугаар хавсралтад дурьдсан шон болон хашааг акталж данснаас хасахыг тус тус зөвшөөрсүгэй.

Хоёр. Дэрэн сумын Цэцэрлэгийн эрхлэгч Р.Нэргүй, Дэрэн сумын Засаг дарга Н.Мядагмаа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай: Үүнд:

- 2.1 Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах.
- 2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх
- 2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2020 оны 4 дүгээр сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 03 дугаар сарын
23-ний өдрийн 34 тогтоолын нэгдүгээр хавсралт

**Дэрэн сумын Цэцэрлэгийн үндсэн хөрөнгийг балансаас,
балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт**

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Хэмжээ	Тоо	Нэгжийн үнэ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
1	Хашаа	2007-07-01	ш	30	21,690	650,700	65,070	585,630
2	Шон	2007-01-07	ш	14	4,217.50	59,045	5,905.20	53,139.80
3	Төмөр хашаа	2018-12-31	ш	19 1	13,437.78 13,437.94	255,317.82 13,437.94	31,915.44 1,679.76	223,402.38 11,758.18
Нийт дүн						978,500.76 /есөн зуун далан найман мянга таван зуу төгрөг/ далан зургаан мөнгө	104,570.4 /нэг зуун дөрвөн мянга таван зуун далан төгрөг/ дөрвөн мөнгө	873,930.36 /найман зуун далан гурван мянга есөн зуун гучин төгрөг/ гучин зургаан мөнгө

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 23 дугаар сарын
23-ний өдрийн 34 тогтоолын хоёрдугаар хавсралт

**Дэрэн сумын Цэцэрлэгийн үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах хөрөнгийн жагсаалт**

№	Хөрөнгийн нэр	Ашиглалт анд орсон огноо	Хэмжээ	Тоо	Нэгжийн үнэ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
1	Шон	2010-02-09	ш	1	30,000	30,000	28,000	2,000
2	Төмөр хашаа	2018-12-31	ш	30 1	3,775.06 3,775.09	113,251.80 3,775.09	14,155.20 471.84	99,096.60 3,303.25
3	Хашаа	2018-12-31	ш	8 1	5,934.77 5,934.83	47,478.16 5,934.83	4,748.16 741.84	42,730 5,192.99
4	Төмөр хашаа	2018-12-31	ш	8	8,121.74	64,973.92	8,121.60	56,852.32
Нийт						265,413.8 /хоёр зуун жаран таван мянга дөрвөн зуун арван гурван төгрөг/ найман мөнгө	56,238.64 /тавин зургаан мянга хоёр зуун гучин найман төгрөг/ жаран дөрвөн мөнгө	209,175.16 /хоёр зуун есөн мянга нэг зуун далан таван төгрөг/ арван зургаан мөнгө



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2020 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 25

Мандалговь

“Үл хөдлөх хөрөнгөд үнэлгээ тогтоож, худалдах,
акталж данснаас хасах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 6.2.1, 6.4 дэх хэсгийн 6.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Дундговь аймгийн Дэрэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 868,632 /найман зуун жаран найман мянга зургаан зуун гучин хоёр/ төгрөгийн балансын үнэтэй, 700,797 /долоон зуун мянган долоон зуун ерэн долоо/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй, аж ахуйн хашааны худалдах доод үнийг 250,000 /хоёр зуун тавин мянга/ төгрөгөөр, хоёр модон складын худалдах доод үнийг тус бүрийг нь 350,000 /гурван зуун тавин мянга/ төгрөгөөр хавсралтын дагуу тогтоон дуудлага худалдаагаар худалдахыг зөвшөөрсүгэй.

Хоёр: Эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

Гурав: Эд хөрөнгийг худалдсаны дараа холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэхийг Дэрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал (Д.Мөнхтогтох)-д даалгасугай.

Дөрөв. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 2 дугаар сарын
28-ний өдрийн 45 тогтоолын хавсралт

Дэрэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн хөрөнгө худалдах хөрөнгийн жагсаалт

№	Барилга, байгууламжийн нэр	Зориулалт	Хэмжих нэгж		Ашиглагтан дорсон огноо	Ашиглалтын нийт хугацаа /жилээр/	Балансын үнэ	Хуримтлагдсан н элэгдэл	Үлдэгдэл өртөг	Дуудлага худалдааны үнэ	
			Хэмжих нэгж	Биет хэмжээ							
1	Модон сжгад	сжгад	ш	7*5	1978-01-01	6	372,494.61	62,082.48	310,412.13	350,000	
2	Хүрэн сжгад	сжгад	ш	7*5	1978-01-01	6	219,377.83	36,562.92	182,814.91	350,000	
3	Аж ахуйн хашаа	сжгад	ш		1978-01-01	4	276,760.25	69,190.08	207,570.17	250,000	
Нийт дүн								868,632.69 /найм зуун жаран найман мянга зургаан зуун гучин хоёр төгрөг жаран есөн мөнгө/	167,835.48 /нэг зуун жаран долоон мянга найман зуун гучин таван төгрөг дөчин найман мөнгө/	700,797.21 /долоон зуун мянга долоон зуун ерэн долоон төгрөг хорин нэгэн мөнгө/	950,000 /есөн зуун тавин мянган төгрөг/



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2020 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 36

Мандалговь

Үндсэн хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт шаардлагатай нийт 51,268,100 /тавин нэгэн сая хоёр зуун жаран найман мянга нэг зуун/ төгрөгийн тоног төхөөрөмжийг хавсралтын дагуу бэлтгэж үндсэн хөрөнгөнд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр. Аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын дарга (Б.Мөнхжаргал)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай. Үүнд:

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2020 оны 4 дүгээр сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх;

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ) -д үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 23 дугаар сарын
23 ний өдрийн 26 тогтоолын хавсралт

Хүнс хөдөө аж ахуйн газрын үндсэн хөрөнгөнд бүртгэх жагсаалт

№	Нэр	Нэг бүрийн үнэ	Хэмжих нэгж	Тоо	Дүн
1	Фургон УАЗ-22069	36,000,000.00	ш	1	36,000,000.00
2	Усны түвшин хэмжигч 150 метр	3,779,600.00	ш	1	3,779,600.00
3	Санхүүгийн программ	1,500,000.00	ш	1	1,500,000.00
4	Чанга яригч	320,000.00	ш	1	320,000.00
5	Гар GPS 64	815,000.00	ш	1	815,000.00
6	Дарга сандал	1,269,900.00	ш	1	1,269,900.00
7	Dell-It ins 3593 notebook	1,899,900.00	ш	1	1,899,900.00
8	Dell-It ins 558 note book	2,799,900.00	ш	1	2,799,900.00
9	Принтер M130A	419,900.00	ш	1	419,900.00
10	Тоос сорогч / Dana-Mc YL635 /	549,900.00	ш	1	549,900.00
11	Epson l1300 өнгөт принтер	1,320,000.00	ш	1	1,320,000.00
12	Свийч /1016 /	594,000.00	ш	1	594,000.00
Нийт дүн				12	51,268,100.00 /тавин нэгэн сая хоёр зуун жаран найман мянга нэг зуун төгрөг/



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2020 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 34

Мандалговь

“Үл хөдлөх хөрөнгөд үнэлгээ тогтоож, худалдах,
акталж данснаас хасах, үндсэн хөрөнгө бүртгэх”

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 6.2.1, 6.4 дэх хэсгийн 6.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Баянжаргалан сумын Засаг даргын тамгын газарт шаардлагатай нийт 6,919,000 /зургаан сая есөн зуун арван есөн мянга/ төгрөгийн үнэтэй, нэгдүгээр хавсралтад дурьдсан тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгөнд бүртгэх, 5,000,000 /таван сая/ төгрөгийн балансын үнэтэй, 3,222,216 /Гурван сая хоёр зуун хорин хоёр мянга хоёр зуун арван зургаа/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй, хоёрдугаар хавсралтад дурьдсан хашааны шонг акталж, данснаас хасах, 20,319,575 /хорин сая гурван зуун арван есөн мянга таван зуун далан тав/ төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй Цэцэрлэгийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй гуравдугаар хавсралтад дурьдсан хуучин эмнэлгийн чулуун барилгыг, хашааны хамт акталж данснаас хасах, 17,000,000 /арван долоон сая/ төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй 49-21 ДУА улсын дугаартай SUBARU Forester маркийн автомашины дуудлага худалдаанд худалдах доод үнийг 1,000,000 /нэг сая/ төгрөгөөр тогтоож дуудлага худалдаагаар худалдахыг тус тус зөвшөөрсүгэй.

Хоёр. Баянжаргалан сумын Засаг даргын тамгын газрын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Сувд)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай. Үүнд:

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

Гурав. Эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Бат-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

Дөрөв. Эд хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад дор акталж устган данснаас хассаны дараа холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэж, тогтоолын биелэлтийг хангаж ажиллахыг Цэцэрлэгийн эрхлэгч (Б.Цэцэгжаргал)-д даалгасугай.

Тав. Барилгаас гарсан борлуулсан орлогыг барилга буулгаж зөөх зардалд зарцуулахыг дурдсугай.

Зургаа. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ) -д үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 23 дугаар сарын
23-ний өдрийн 37 тогтоолын нэгдүгээр хавсралт

ЗДТГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэх жагсаалт

№	Нэр төрөл	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт дүн
1	УС түгээх дэлгэц	1	650,000	650,000
2	Түгээх самбар иж бүрэн тоноглогдсон	1	3,960,000	3,960,000
3	Импульсэн тоолуур	1	268,000	268,000
4	Хяналтын камер гадна	1	210,000	210,000
5	Хяналтын камер дотор	1	150,000	150,000
6	Камер бичигч	1	320,000	320,000
7	Цахилгаан халаагуур	1	251,000	251,000
8	Вакум насос	1	310,000	310,000
9	Нөөцийн сав	1	800,000	800,000
Нийт дүн			6,919,000 /зургаан сая есөн зуун арван есөн мянган/ төгрөг	6,919,000 /зургаан сая есөн зуун арван есөн мянган/ төгрөг

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 23 дугаар сарын
23-ний өдрийн 37 тогтоолын хоёрдугаар хавсралт

**Баянжаргалан сумын ЗДТГазрын акталж, данснаас
хасах хөрөнгийн мэдээлэл**

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Хэмжээ	Тоо	Нэгжийн үнэ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
1	Булгын эх /хашаа/	2014-11-18	ш	42	95,238.09	3,999,999.78	1,322,211.90	2,611,111.28
2	Булгын эх /шон/	2014-11-18	ш	74	13,513.52	1,000,000.22	372,226.76	611,105.70
Нийт дүн						5,000,000 /таван сая төгрөг/	1,694,448.66 /нэг сая зургаан зуун ерэн дөрвөн мянга дөрвөн зуун дөчин найман төгрөг/ жаран зургаан мөнгө	3,222,216.98 /гурван сая хоёр зуун хорин хоёр мянга хоёр зуун арван зургаан төгрөг/ ерэн найман мөнгө

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 23 дугаар сарын
23-ний өдрийн 37 тогтоолын гуравдугаар хавсралт

Баянжаргалан сумын Цэцэрлэгийн акталж, данснаас хасах хөрөнгийн мэдээлэл

№	Хөрөнгийн нэр	Ашиглалт анд орсон огноо	Хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
1	Хашаа	2014-05-12	ш	71	15,000	3,999,999.78	15,000	-
2	Цагаан цэцэрлэг	1970-01-01	ш	1	19,254,575	19,254,575	19,254,575	-
Нийт дүн						20,319,575 /хорин сая гурван зуун арван есөн мянга таван зуун далан таван төгрөг/	19,269,575 /арван есөн сая хоёр зуун жаран есөн мянга таван зуун далан таван төгрөг/	-

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 23 дугаар сарын
23-ний өдрийн 37 тогтоолын хавсралт

**Баянжаргалан сумын цэцэрлэгийн актлах барилгыг
устгахад шаардагдах үнэлгээ**

№	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Вакум цонх	ш	6	30,000	180,000
2	Хаалга	ш	4	20,000	80,000
3	Вакум хаалга	ш	1	50,000	50,000
4	Дүүжин тааз	ш	50	1,000	50,000
5	Дээврийн төмөр	ш	40	1,000	40,000
	Нийт дүн				400,000 /Дөрвөн зуун мянган төгрөг/



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2020 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 38

Мандалговь

Үндсэн хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэст шаардлагатай нийт 5,250,000 /таван сая хоёр зуун тавин мянга/ төгрөгийн үнэтэй тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгөнд хавсралтын дагуу бүртгэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр. Аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн дарга (Б.Энхтуяа)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай. Үүнд:

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2020 оны 4 дүгээр сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх;

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ) -д үүрэг болгосугай.

ДАРГА С.С. С.СҮХБААТАР



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 03 дугаар сарын
03-ний өдрийн 38 тогтоолын хавсралт

Статистикийн хэлтэст үндсэн хөрөнгө бүртгэх хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Notebook	ш	1	2,600,000.00	2,600,000.00
2	Зургийн аппарат	ш	1	1,100,000.00	1,100,000.00
3	Цаас зүсэгч	ш	1	300,000.00	300,000.00
4	Ширээ	ш	1	280,000.00	280,000.00
5	Хурлын ширээ	ш	1	250,000.00	250,000.00
6	Шкаф	ш	1	320,000.00	320,000.00
7	Шүүгээ	ш	1	120,000.00	120,000.00
8	Принтер	ш	1	280,000.00	280,000.00
Нийт дүн				5,250,000 /таван сая хоёр зуун тавин мянган/ төгрөг	5,250,000 /таван сая хоёр зуун тавин мянган/ төгрөг



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2020 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 39

Мандалговь

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 6.2.1, 6.4 дэх хэсгийн 6.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Сайхан-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 346,788,858 /гурван зуун дөчин зургаан сая долоон зуун наян найман мянга найман зуун тавин найм/ төгрөгийн балансын үнэтэй үлдэгдэл өртөггүй хавсралтад дурьдсан барилга байгууламжийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

Хоёр. Эд хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад дор акталж устган данснаас хассаны дараа холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэж, тогтоолын биелэлтийг хангаж ажиллахыг Ерөнхий боловсролын сургуулийн захирал (С.Оюунболд)-д даалгасугай.

Гурав. Барилгыг буулгах зөөх ажлын хөлсөнд барилгын материалыг үнэлж зарцуулахыг дурдсугай.

Дөрөв. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА С.СҮХБААТАР



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 2 дугаар сарын
23 ний өдрийн 29 тогтоолын хавсралт
Сайхан-Овоо сумын Ерөнхий боловсролын ахлах, данснаас хасах барилга байгууламжийн мэдээлэл

№	Барилга. байгууламжийн нэр	Зориулалт	Хүчин чадлал		Ашиглалт тэд орсон огноо	Ашиглалтын нийт хугацаа /жигээр/	Тоо	Нэг бүрийн үнэ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
			Хэмжих нэгж	биет хэмжээ							
1	Дотуур байр	Хүүхдийн байр	ш	60	1986	34	1	147406170	147406170	-	
2	Склад	Склад	ш	154	1951	69	1	2901192	2901192	-	
3	Орон сууц 1940	4 айл	ш	131	1940	80	1	43904700	43904700	-	
4	Склад 1940/шоон/	Склад	ш	111	1940	80	1	4737860	4737860	-	
5	Үйлчилгээний байр 1962	Склад	ш	224	1962	58	1	147838936	147838936	-	
								346,788,858	346,788,858		
								/гурван зуун дөчин зургаан сая долгон зуун наян найман мянга найман зуун тавин найман төгрөг/	/гурван зуун дөчин зургаан сая долгон зуун наян найман мянга найман зуун тавин найман төгрөг/		

Нийт дүн



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2020 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 40

Мандалговь

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 6.2.1, 6.4 дэх хэсгийн 6.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Г.Тувааны нэрэмжит Дундговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн 40,152,816 /дөчин сая нэг зуун тавин хоёр мянга найман зуун арван зургаа/ төгрөгийн балансын үнэтэй 34,506,857 /Гучин дөрвөн сая таван зуун зургаан мянга найман зуун тавин долоо/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй хавсралтад дурьдсан барилга байгууламжийг акталж данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

Хоёр. Эд хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад дор акталж, акталснаас гарсан эргэлтийн хөрөнгийг тооцож хөрөнгө борлуулсаний орлогод төвлөрүүлэн данснаас хассаны дараа холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэж, тогтоолын биелэлтийг хангаж ажиллахыг Г.Тувааны нэрэмжит Дундговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга (Х.Жаргал)-д даалгасугай.

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 3 дугаар сарын
22-ний өдрийн 10 тогтоолын хавсралт

Нэгдсэн эмнэлгийн актлаж, данснаас хасах барилга байгууламжийн мэдээлэл

№	Барилга. байгууламжийн нэр	Зориулалт	Хүчин чадал		Ашиглагдах орсон огноо	Ашигласны хугацаа /жилээр/	Тоо	Нэг бүрийн үнэ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
			Хэмжээ	Биет хэмжээ							
1	Гражийн контор	Эмнэлэг	Ш	1	1986	34	1	3,978,816	3,785,401.20	193,414.80	
2	Гражийн Пүтик	Эмнэлэг	Ш	1	1986	34	1	281,500	281,500	-	
3	Автогражийн склад	Агуулах	Ш	1	2019	13	1	13,389,800	425,073.04	12,964,726.96	
4	Автограж	Эмнэлэг	Ш	1	2019	13	1	22,502,700	1,153,984.64	21,348,715.36	
								40,152,816	5,645,958.88	34,506,857.12	
								/дөчин сая нэг зуун тавин хоёр мянга найман зуун арван зургаа төгрөг/	/таван сая зургаан зуун дөчин таван мянга есөн зуун тавин найм төгрөг/	Гучин дөрвөн сая таван зуун зургаан мянга найман зуун тавин долоо төгрөг/ арван хоёр мөнгө	

Нийт дүн



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2020 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 41

Мандалговь

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалтыг 6.2.1, 6.4 дэх заалтыг 6.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 883,844 /найман зуун наян гурван мянга найман зуун дөчин дөрөв/ төгрөгийн балансын үнэтэй, 302,417 /гурван зуун хоёр мянга дөрвөн зуун арван долоо/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй хавсралтад дурьдсан эд хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

Хоёр. Эд хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад дор акталж устган данснаас хассаны дараа холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэж, тогтоолын биелэлтийг хангаж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА С.СҮХБААТАР



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 03 дугаар сарын
23 ний өдрийн 11 тогтоолын хавсралт

Орон нутгийн өмчийн газрын акталж, данснаас хасах хөрөнгийн мэдээлэл

№	Үндсэн хөрөнгийн		Өртөг			Элэгдлийн дүн	Үлдэгдэл өртөг
	Нэр	х.н	Нэгж.Үнэ	Тоо	Нийт дүн		
1	Notebook	ш	400,000.00	1.00	400,000.00	250,000.05	149,999.95
2	Зөөврийн компьютер	ш	355,511.11	1.00	355,511.11	254,783.04	100,728.08
3	Камер	ш	128,333.40	1.00	128,333.40	76,643.58	51,689.82
НИЙТ ДҮН				3.00	883,844.51/ найман зуун наян гурван мянга найман зуун дөчин дөрөв төгрөг/ тавин нэгэн мөнгө	581,426.67/тава н зуун наян нэгэн мянга дөрвөн зуун хорин зургаан төгрөг/ жаран долоон мөнгө	302,417.85 /Гурван зуун хоёр мянга дөрвөн зуун арван долоо төгрөг/ наян таван мөнгө

ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС

2020 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 2/01

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА О.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

ХЭЛЭЛЦСЭН НЬ: Үл хөдлөх хөрөнгөнд үнэлгээ, тогтоож худалдах тухай /Говь-Угтаал сумын Хуучин хүүхдийн цэцэрлэгийн барилга, газрын хамт/

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ: Дундговь аймгийн Засаг дарга О.Бат-Эрдэнэ, Орон нутгийн өмчийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Бат-Эрдэнэ нар Говь-Угтаал сумын Хүүхдийн цэцэрлэгийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 35,814,533 /гучин таван сая найман зуун арван дөрвөн мянга таван зуун гучин гурав/ төгрөгийн балансын үнэтэй, 20,891,811 /хорин сая найман зуун ерэн нэгэн мянга найман зуун арван нэг/ төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 14,922,722 /арван дөрвөн сая есөн зуун хорин хоёр мянга долоон зуун хорин хоёр/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй Цэцэрлэгийн барилгыг, доорхи газрын хамт худалдах доод үнийг 6,000,000 /зургаан сая/ төгрөгөөр тогтоон дуудлага худалдаанд, худалдах саналтай байна гэж танилцууллаа.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн олонхийн саналаар Говь-Угтаал сумын Хүүхдийн цэцэрлэгийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, хуучин хүүхдийн цэцэрлэг нь сургууль, цэцэрлэгийн орчимд ойрхон учир газрын хамт худалдахад тохиромжгүй, хойшлуулах нь зүйтэй” гэжээ

ДАРГА С.СҮХБААТАР

